

## МОНГОЛ ХЭЛНИЙ “ИНЭЭХ” ҮГТ ЗҮЙР ЦЭЦЭН ҮГИЙН ТАЛААРХ ЗАРИМ АЖИГЛАЛТ

*Д.Отгонцэцэг, Солонгосын Гадаад Судлалын Их Сургууль*

### Abstract

This article addresses the typological features of lexical and non-lexical means of expressing the action of laughter in modern Mongolian, and is a continuation of our recent innovative research on this topic.

The main aim of this paper has been to collect Mongolian proverbs containing the verb *inee-* ‘laugh’ and present certain observations on these proverbs. Specifically, we address the verb *inee-* ‘laugh’ as it occurs in these particular proverbs, and demonstrate its semantic capacity, semantic typology, direct and indirect meanings, as well as its ability to give rise to different semantic fields.

Among the corpus of proverbs, a major genre of Mongolian oral folklore, we specifically chose proverbs with the verb *inee-* ‘laugh’ and based on relevant materials collected to the best of our ability, and based on our observations, it is possible to state the following:

- In terms of structure and formation, Mongolian proverbs with the verb *inee-* ‘laugh’ are derived from couplets. A few instances of quatrains were observed, but these are essentially extended couplets.

- The couplet structure of proverbs with the verb *inee-* ‘laugh’ is characterized by the fact that it is based on antonyms and forms opposing lines or opposing couplets. This is a characteristic of Mongolian proverbs.

- The ability of the word *inee-* ‘laugh’ in the proverbs we chose to form semantic fields is connected with words such as *uil-* ‘cry’, *uurla-* ‘get angry’, *xania-* ‘cough’, *id-* ‘eat’, *ir-* ‘come’, *surga-* ‘teach’, and *unt-* ‘sleep’. The first two of these words form lexical antonyms, and the others form contextual antonyms.

- The verb *inee-* ‘laugh’ in these proverbs is characterized by its ability to form semantic fields both opposing and related to the above-mentioned verbs.

### Түлхүүр үг

Инээх үйлдэл, зүйр цэцэн үг, “инээх” үгт зүйр цэцэн үг, утгазүйн орон, “инээх” үгт зүйр цэцэн үгийн утгазүйн орон.

### Удиртгал

Энэхүү өгүүлэл нь орчин цагийн монгол хэлэнд инээх үйлдэл илэрхийлэх үгэн ба үгэн бус арга хэрэглүүрийн хэв шинжийг тусгайлан сонирхож саяхнаас шинээр эхэлж байгаа бидний ажиглалт судалгааны ажлын нэг хэсэг<sup>2</sup> болох юм.

Бид энэ удаа “инээх” гэдэг үйл үг бүрэлдэхүүнд нь оролцсон зүйр цэцэн үгийг<sup>3</sup> түүвэрлэн цуглуулж, тодорхой ажиглалт хийхийг гол зорилго болгосон билээ. Тодруулбал, “зүйр цэцэн үг нэг бүр нь нэг талаас хэлний үзэгдлийн хувьд өвөрмөц тогтмол хэллэгийн зүйл мөн” (Гаадамба, Сампилдэндэв, 1988, х.178) болохоор тухайн зүйр цэцэн үгийн бүрэлдэхүүнд багтсан “инээх” гэдэг үйл үгийн утгазүйн багтаамж, утгын хэв шинж, энэ үйл үгийн шууд ба шилжсэн утга,

тэрчлэн утгазүйн орон үүсгэх чадамж зэргийг олж тогтооход голлон анхаарсан болно.

### 1. “Инээх” үгт зүйр цэцэн үгийн бүтцийн хэв шинж

Монгол хэлний зүйр цэцэн үгийн бүтэц, уг бүтцийг үүсгэж байгаа шүлгийн хэлбэрийн талаарх судалгааны тоймоос үзэхэд утга зохиол, аман зохиол судлаач эрдэмтэд сонирхолтой ажиглалт дүгнэлт гаргасан байна. Үүнийг товчлон хураангуйлбал, монгол ардын зүйр цэцэн үгийн “... шүлгийн хэлбэрийн үүднээс нь холбоо буюу хошоо үг, гурвал үг, дөрвөл үг, бадаг үг гэх зэргээр ялган хэлэлцэж болно” (Гаадамба, Сампилдэндэв, 1988, х.173), “хэлбэрийн талаас нь холбоо буюу хоршоо үг, гурвал үг, дөрвөл үг” гэж хуваах саналыг

<sup>2</sup>Д.Отгонцэцэг. Монгол хэлэнд инээх үйлдэл илэрхийлэх нь. - Monggolhak몽골학 (Mongolian Studies). Journal of The Korean Association for Mongolian Studies. Republic of Korea. Seoul

Д.Отгонцэцэг. Инээх үйлдэл зохиолын баатрын хэв шинжийг илэрхийлэх нь (Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы Итгэлтийн инээх үйлдлийн жишээгээр). - “Лавай”. № 12. Эрдэм шинжилгээний бичиг.

Д.Отгонцэцэг. Зохиолын баатрын хэв шинжийг инээх үйлдлээр илэрхийлэх нь (Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы зарим дүрийн инээх үйлдлийн жишээгээр). - Monggolhak몽골학 (Mongolian Studies). Journal of The Korean Association for Mongolian Studies. Republic of Korea. Seoul.

<sup>3</sup>Утга зохиол, аман зохиол судлаачид зүйр цэцэн үг гэдэг энэхүү харьцангуй тогтвортой, бүлэг хэллэгийг дотор нь зүйр үг, цэцэн үг, эсвэл зүйр үг, цэцэн үг, мэргэн үг, эсвэл зүгээр л зүйр цэцэн үг гэж ерөнхийлөн нэрлэсэн байдаг бөгөөд бид энэхүү өгүүллэдээ сүүлийн нэршлийг нэг мөр хэрэглэсэн болно. Ер нь судалгааны тоймоос үзвэл “Монгол ардын зүйр цэцэн үгийн хэлбэр, агуулга, үүргийн талыг нь харгалзан бодит амьдралын юмс үзэгдлийг анализ, синтезийн аргаар нэгтгэж дүгнэснийг *цэцэн үг*, аналогийн аргаар зүйрлэн жишиж илтгэснийг *зүйр үг*, яриаг оновчтой бөгөөд чимэгтэй болгох үүрэгтэй үгсийг *мэргэн үг* хэмээн ялгавартай үзэж болох юм” (Эрдэнэ-Очир Г., 1983:3) гэсэн тодорхойлолт ихээхэн сонирхолтой байна.

зарим судлаач дэвшүүлжээ” (Ринчэнсамбуу, 2002, х.4), “шүлгийн бүтэц нь голдуу Монголын эртний уламжлалт хос холбоцын маягтай хоёр мөрт юм уу эн зэрэгцүүлэх аргаар холбосон дөрвөн мөртөөс бүтдэг байна” (Цэрэнсодном, 2012, х.49) гэх мэтээр дурджээ.

Эндээс үзвэл зүйр цэцэн үгийн бүрэлдэх бүтцийн хувьд холбоо үг, хошоо үг, гурвал үг, дөрвөл үг, бадаг үг, хоршоо үг, хоёр мөрт, дөрвөн мөрт гэсэн нэр томъёоны шинжтэй нэрлэлт үүссэн байх бөгөөд холбоо үг, хошоо үг, хоршоо үг, хоёр мөрт гэдэг нь хоёрлосон бүтэц; гурвал үг гэдэг нь гурвалсан бүтэц; бадаг үг, дөрвөн мөрт гэдэг нь дөрвөлсөн бүтэц гэж хялбархан бүлэглэж болох юм.

Энэ дагуу монгол хэлний “инээх” үгт зүйр цэцэн үгийн бүтцийг ажиглавал ихэвчлэн хоёр мөрт, цөөн тохиолдолд дөрвөн мөрт бүртгэгдлээ. Үүнд:

а. Хоёр мөрт зүйр цэцэн үг. Ийм хэв шинжийн зүйр цэцэн үг бидний түүвэрлэсэн нийт жишээний дийлэнх буюу ер гаруй хувийг эзэлж байна. Жишээлбэл:

Инээснийг асуу

Уйлсныг бүү асуу

Энэхүү зүйр цэцэн үг нь хоёрлосон бүтцэд суурилсан, хоёр мөр нь өөр хоорондоо “инээх” - “уйлах” гэсэн үгийн эсрэгцлээр эсрэгцлийн эгнээ үүсгэсэн, “асуу” гэдэг үгээр сүүл холбосон, “инээснийг асуу-”, “уйлсныг бүү асуу-” гэсэн хоёр чөлөөт холбоо үгийн загвараар бүтсэн хоёр бүрэн бус, захирах өгүүлбэрийн шинжтэй ажээ. Эндээс “асуу-”, “бүү асуу-” гэдэг үйл үг нь эсрэг утгат үгийн эгнээ үүсгэж байгаа тул “инээ-”, “уйл-” гэсэн үйл үг нь мөн ялгаагүй үгийн сангийн шинжтэй эсрэг утгат үгийн эгнээ үүсгэж байна.

б. Дөрвөн мөрт зүйр цэцэн үг. Энэхүү хэв шинжид хамаарах зүйр цэцэн үг харьцангуй цөөн бүртгэгдсэн. Жишээлбэл:

Идэх юм харахаар

Инээд нь хүрдэг

Сурах юм харахаар

Нойр нь хүрдэг

Энэхүү зүйр цэцэн үг нь хоёрлосон бүтцэд суурилсан дөрвөлсөн бүтэцтэй, эхний хоёр мөр нь толгой холбосон, 1 ба 3 дахь мөр нь “харахаар” гэдэг үгээр, 2 ба 4 дэх мөр нь “хүрдэг” гэдэг үгээр тус тус сүүл холбосон, 1 ба 3 дахь мөр нь “идэх юм” – “сурах юм” гэсэн чөлөөт холбоо үгээр, 2 ба 4 дэх мөр нь “инээд нь хүрдэг” - “нойр нь хүрдэг” гэсэн хэллэгийн эсрэгцэл дээр суурилсан байдалтай, мөрийн доторх үгийн тоо тэгширсэн, шалтгааны утгат хоёр байц гишүүн өгүүлбэрийн загвар үүсгэсэн байх ажээ. Эндээс “идэх юм” – “сурах юм”, “инээд нь хүрдэг” - “нойр нь хүрдэг” гэсэн эсрэгцэл нь хам эхийн шинжтэй эсрэг утгат

үгийн эгнээ үүсгэж байна.

Бидний бүртгэсэн жишээнд зүйр цэцэн үгийн “гурвал үг” гэдэг хэв шинжид хамаарагдах баримт одоо хэр хараахан олдоогүй байна.

## 2. “Инээх” үгт зүйр цэцэн үгийн утгазүйн орон үүсгэх чадамж

Монгол хэлний “инээх” үгт зүйр цэцэн үгийн дээр өгүүлсэн бүтцийн загвараас үүдэн энэхүү хэв шинжийн хэллэгийн утгазүйн орон үүсгэх чадамжийг тодорхойлж болох юм.

Ер нь “зүйр цэцэн үгийг бүтээх материал нь үг, түүнээс бүтэх бүрэн, буюу бүрэн бус өгүүлбэр байдаг” (Гаадамба, Сампилдэндэв, 1988, х.191) болохоор бүрэлдэхүүнд нь “инээх” гэдэг үг голлон оролцож, уг хэллэгийн утгазүйн цөмийг үүсгэж байгаа зүйр цэцэн үгийн утгазүйн орон тогтоох нь бидний нэг зорилго юм.

Бүртгэн цуглуулсан хэрэглэгдэхүүний хүрээнд ажиглахад “инээх” үгт зүйр цэцэн үгийн хоёрлосон буюу хоёр мөрт бүтцийн эхний мөрөнд нь “инээх” гэдэг үг оролцсон бол дараагийн хоёр дахь мөрөнд нь инээх үйлдлийн эсрэг шинжтэй үг тохиолддог байна. Тодруулбал, уул хоёр мөр нь бүхэлдээ эсрэгцсэн шинжтэй, эсрэгцлийн эгнээ үүсгэсэн, эсрэг мөрт бөгөөд энэхүү эсрэгцлийн эгнээг үүсгэж байгаа үг нь нэг талаас “инээх үг”, нөгөө талаас “бусад үг” гэсэн загвар үүсгэж, тэрхүү бусад үгийн байранд янз бүрийн хэв шинж бүхий үйл үг, нэр үг тохиолдох боломжтой ажээ. Цуглуулж авсан жишээ баримтад үндэслэн “инээх үг” + “бусад үг” гэсэн загвараар ялгаж, давтамжийн уруудах дараалалд оруулж үзвэл бусад үгийн байранд дараах үйл үг тохиолдож байгаа нь ажиглагдлаа. Үүнд:

(а) инээх - уйлах

(б) инээх - уурлах

(в) инээх - ханиах

(г) инээх - идэх

(д) инээх - ирэх

(е) инээх - сургах

(ё) инээх - унтах

Энэхүү эсрэгцлийн эгнээнээс үзвэл хамгийн өндөр давтамжтай (а) (б) эсрэгцэл нь ерөнхийдөө үгийн сангийн эсрэг үгэнд тулгуурласан шинжтэй бол (в) нь хам сэдвийн эсрэг үгийн харьцангуй бат холбоонд суурилсан, харин (г) (д) (е) (ё) нь хам сэдвийн эсрэг үгийн төсөөгөөр үүссэн, маш сул холбоогоор холбогдсон байдалтай гэж үзмээр байна.

Түүвэрлэн цуглуулж авсан “инээх” үгт зүйр цэцэн үгийн хүрээнд “инээх үг” ба “бусад үг” гэсэн загвараар томъёолон бүртгэсэн эсрэгцлийн энэхүү 7 зүйлийг тус бүрд нь товчхон товчоолж, үүнд холбогдох судлаачдын урьд өмнө хийсэн

утгын тайлбарыг мөн дор бүрд нь хадан давхар баталгаажуулж, тэрчлэн тайлбар толийн стандарт тайлбараар магадлан тодорхойлохыг оролдов. Үүнд:

**(а) инээх – уйлах**

“Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д энэхүү “инээх” гэдэг үйл үгийг” 1. Баярлах, баясах, хөөрөх, сэтгэл таатай болох зэрэг сэтгэлийн хөдөлгөөн нүүр нүд, дуу аялгаар илрэх; 2. Сэтгэлийн баяр хөөрлийг бус шоглол, дургүйцэл, эсэргүүцлийн өнгө аясыг илэрхийлэн гаргах; 3. Нүд, сормуусаа хөдөлгөн сэтгэлийн дотоод илрэлийг гаргах; инээх байдал илтгэх: ...” (Болд, 2008, х.1117 б -1118 а), “уйлах” гэдэг үйл үгийг “1. Өвдөх, гомдох зэрэг сэтгэл хөдлөлөөс болж нүднээс нулимс гарах; 2. Эргэлдэх, тойрох...” (Болд, 2008, х.2188 б - 2189 а) хэмээн тус тус тайлбарласан байна.

Тайлбар толь бичгийн тодорхойлолт болон дор түүвэрлэн тайлбарын хамт эшлэн оруулсан зүйр цэцэн үгийн жишээнээс үзэхэд “инээх”, “уйлах” гэдэг үйл үгс нь үгийн сангийн өгөгдсөн, цөм, үндсэн утга буюу тайлбар толины нэгдүгээр утгаараа өөр хоорондоо эсрэг үгийн эгнээ<sup>4</sup> үүсгэн эсрэгцлийн хоёр гишүүн болж байна.

Энэ хэв шинжийн зүйр цэцэн үгийн түүвэр болон холбогдох тайлбар, ажиглалт дүгнэлтийг дараах байдлаар товчоолон үзүүлье.

Үүнд:

Буруу харж уйлаад

Зөв харж инээх “Хүчинд автсан байдалд ороод арга буюу аялдан дагалдах хэлбэрийг үзүүлсэн дүрслэл. Үлгэр туульд хүчирхийлэн дарлагч, мангас шуламсын гарт орсон нөхцөлд дурдагдах нь олонтоо” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.89 б).

Зөв харж инээж

Буруу харж уйлах

“Бусдад өөрийн үнэтэй, чухал хэрэгцээтэй, хайр хүндэтгэлтэй юмаа өгөхөд илэрдэг сэтгэлийн илрэлийг тэмдэглэсэн санаа” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.183 а).

Наашаа харж инээж

Цаашаа харж уйлах

“Сэтгэлд үл нийцэх боловч аргагүйн эрхэнд аяыг нь дагахыг дүрсэлсэн хэллэг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.253 б).

Энд өгөгдсөн гурван зүйр цэцэн үг нь үндсэндээ ойролцоо утгат хэллэгүүд бөгөөд эхний хоёр нь “буруу - зөв”, “зөв - буруу” гэсэн эсрэгцэл дээр үндэслэсэн хувилбар харьцаатай ажээ. Мөн “зөв” ба “буруу” нь үгийн сангийн эсрэг утгат үг бол “зөв – наашаа”, “буруу – цаашаа” нь хам сэдвийн эсрэг утгат үгийн шинжтэй юм.

Билүүгээр жанчихад инээж

Булгаар зүлгэхэд уйлах

“Хал үзэж, зовлон туулсан хүн бол ямар ч хатуу бэрхийг даван, харин зөөлөнд бол уярна гэсэн санаа” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.76 б).

Бургасаар нүдэхэд инээж

Булгаар зүлгэхэд уйлах

Булаар жанчихад инээж

Булгаар зүлгэхэд уйлна

“Хүний хатууд хатуу зөөлөнд зөөлөн харьцах сайн зан чанарыг илэрхийлсэн хэллэг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.87 а).

Энэхүү гурван зүйр цэцэн үг нь мөн л ойролцоо утгат хэллэгүүд бөгөөд зүйр үг тус бүрийн хоёр дахь мөрөнд нь ижилхэн гурав давтагдсан “булгаар зүлгэх” гэдэг холбоо үгэнд уг гурван зүйр үгийн эхний мөрүүдийн “билүүгээр жанчих”, “бургасаар нүдэх”, “булаар жанчих” гэсэн гурван холбоо үг эсрэг утгат хэллэгийн эгнээ үүсгэн хэлбэржсэн байна.

Инээснийг асуу

Уйлсныг бүү асуу

Инээсэн хүнийг асуу

Уйлсан хүнийг бүү асуу

“Хүний сэтгэлийн хөөрөл хөдөлгөөнтэй уялдуулж, харилцаж бай гэсэн сургамж үг юм. Хоёрдох нь ямар нэг зовлон шаналалд учирсан байж болох тул сэтгэлийг нь бүү хөнд гэсэн санаа” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 б).

Уйлсан хүнийг аргад

Инээсэн хүнийг асуу

“Хүний сэтгэл санааны байдалд зохицуулж харилцаж хандаж бай гэсэн санамж” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.414 а).

Уйлсан хүний учир бүү асуу

Инээсэн хүний учир асуу

<sup>4</sup>“Монгол хэвшмэл хэлц, эсрэг утгат үгээр байх нь элбэг. Жишээ нь: Уйлсаар уйлсаар хавар наашаа, инээсээр инээсээр намар цаашаа хэмээх хэлцэд уйлах – инээх, хавар – намар, наашаа – цаашаа хэмээх зургаан үг гурван хос эсрэг утгат үг орсон байнам” (Бадамдорж Д, 2006:205) гэснийг энд холбогдуулан оруулж болох юм.

Дээрх дөрвөн зүйр цэцэн үг нь агуулгын хувьд ойролцоо утгат хэллэгийн шинжтэй байна.

Уярах уйлах  
Баярлах инээх  
Уярахад уйлах  
Баярлахад инээх

“Сэтгэцийн үзэгдэл гарч илрэхдээ эерэг үйл эсрэгээр илрэхийг зүйрлэсэн хэллэг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.444 б).

Энэ хоёр зүйр цэцэн үг нь ерөнхийдөө агуулгын талаасаа мөн хувилбар харьцаанд оршиж байна.

Ярзайвал инээх дүртэй  
Ярвайвал уйлах дүртэй.

“Угийн муухай царайтай нүдэнд хүйтэн этгээд гэж дургүйцэн жигшсэн хэллэг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.643 а).

Иржийвэл инээх дуртай  
Ярвайвал уйлах дуртай  
“Амар засрахгүй ноомой зантай гэсэн санаа” (Болд, 2008, х.1121 а)

Энд дурдсан хоёр зүйр цэцэн үг нь “ярзайх” ба “иржийх”, “дүртэй” ба “дуртай” гэдэг хошоод үгээр ялгарсан хэдий ч бүтцийн хувьд хувилбар шинжтэй хэллэгүүд бөгөөд харин тайлбарууд нь өөр хоорондоо үлэмж ялгаатай юм.

Их инээд  
Эцэстээ нулимстай  
Муу инээхээр  
Сайн уйл

“Бага насанд инээх хөхрөх шалтаг олон байдаг. Шуугианаас бэрхшээсэн ахмад насныхан тэднийг зэмлэж хэлдэг улиг үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.233 а).

Уйлах ихдэх  
Инээх багадах  
Баярлаад инээдэг  
Багтраад уйлдаг

“Энэ бол зан төрхийн энгийн илрэл. Инээх уурлахын завсрыг сахь гэсэн л үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.73 а).

Уйлсаар уйлсаар хавар наашаа  
Инээсээр инээсээр намар цаашаа  
Хаврын тэнгэр уйлсаар уйлсаар наашаан

Намрын тэнгэр инээсээр инээсээр цаашаан  
“Хавар намрын дулаарах хүйтрэхийг харьцуулсан танин мэдэхүйн санамж” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.475 б).

### (б) инээх - уурлах

“Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д “уурлах” гэдэг үйл үгийг 1. Хэрэг явдалд дургүйцсэнээс муу үг хэлж, цухалдах, хилэгнэх; 2. хуучирсан Дотроо муу санах...” (Болд, 2008, х. 2260 а б) гэж тодорхойлжээ.

Тайлбар толь бичгийн тодорхойлолт болон тухайн хэв шинжийн зүйр цэцэн үгийн талаарх утгын тайлбараас харахад “инээх” болон “уурлах” гэдэг үйл үг нь үгийн сангийн үндсэн утгаараа эсрэгцэж, эсрэгцлийн эгнээг үүсгэсэн шинжтэй байна.

Энэ хэв шинжийн зүйр цэцэн үгийн түүвэр болон холбогдох тайлбар, ажиглалт дүгнэлтийг дараах байдлаар товчоолон үзүүлье. Үүнд:

Янаг хүний ярвайх нь ч сайхан  
Өст хүний инээх нь ч муухай

“Хүний хайрлах, үзэн ядах дотоод сэтгэлийн зөрчлийн илрэл” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.642 б).

Янаг хүний ярвайх нь ч бол сайхан  
Өст хүний инээх нь ч бол муухай  
Энэ хоёр зүйр цэцэн үг нь агуулгын талаасаа мөн хувилбар харьцаатай байна.  
Уурласнаараан өвгөрөх  
Инээснээрээн идэрших  
Уурласнаас өвгөрөх  
Инээснээс идэрших

“Сэтгэлийн урвуу өөдрөг үзэгдэл нас биед сөрөг болон эергээр нөлөөлнө гэсэн танин мэдэхүйн агуулгатай хэллэг» (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.439 а) юм.

Энд дурдсан хоёр зүйр цэцэн үг нь “уурласнаараан - уурласнаас”, “инээснээрээн - инээснээс” гэсэн хоёр төсөөт үгийн харьцаанд үндэслэсэн хувилбар хэллэгүүд болсон байна.

Инээсэн бүхэн нөхөр биш  
Уурласан бүхэн дайсан биш

“Хүний зан аашийн илрэлээр түүнийг буруу тийш нь үнэлж болохгүй, өөр эсрэг зан чанартай байж болно гэсэн анхааруулга” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 а).

Инээсэн бүгд итгэлтэй биш  
Эрдэмтэн бүгд тустай биш  
“Итгэл хүндэтгэлийг зөвхөн өнгөн талаас харж хандаж болохгүй чанагуух тал нь ямар ч байж болно гэсэн болгоомжлол” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 а).

Инээсэн бүхнийг  
Нөхөр гэж итгэшгүй  
Элгэн садандаа ч  
Итгэмжтэй үг хэлшгүй  
“Ер нь хүнд итгэх хэцүү, ах дүү садан ч хүртэл итгэх аргагүй гэсэн санаа. Үүнийг харьцангуй авч үзүүштэй. Бүхэнд итгэл алдарсан дэндүү аминч үзэл буюу” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 а).

Эдгээр гурван хэллэг нь агуулгынхаа хувьд ойролцоо утгат хэллэгийн эгнээ үүсгэсэн байна.

Идэх юм харахаар  
Инээд нь хүрдэг  
Сурах юм харахаар  
Уур нь хүрдэг  
Залхуу хүнийг ёгтолж шүүмжилсэн үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.198 а).

Шагнал гэхээр инээж  
Шаардлага тавихаар урвайх  
“Захиргаадлын гол аргыг тусгасан хошигнол” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.595 б).

Энэ хоёр зүйр цэцэн үгийг агуулга, утга санааных нь хувьд ерөнхийдөө төсөөтэй хэллэгүүд гэж үзэж болох юм.

Зөв хэлэхэд инээдэг  
Зүйгүй хэлэхэд урвайдаг  
“Хүний үг сургамжийг хүлээн авах сөрөг хандлагыг егөөдсөн үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.183).

#### **(в) инээх– ханиах**

“Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д “ханиах” гэдэг үйл үгийг “Амьсгалын замыг цочроосноос амьсгалаа хураан огцом хүчтэйгээр хахиран гаргах”(Болд, 2008, х.2443 а) гэж тодорхойлсон байна.

Тайлбартоль бичгийн тодорхойлолт болон тухайн хэв шинжийн зүйр цэцэн үгийн талаарх утгын тайлбараас харахад “инээх” болон “ханиах” гэдэг үйл үг нь үгийн сангийн утгаараа бус, харин хам сэдвийн хүрээнд эсрэгцэж, эсрэгцлийн эгнээг үүсгэсэн байна хэмээн үзүүштэй юм.

Энэ хэв шинжийн зүйр цэцэн үгийн түүвэр болон холбогдох тайлбар, ажиглалт дүгнэлтийг дараах байдлаар товчоолон үзүүлбэ. Үүнд:

Инээд биш ханиад  
Наадам биш наргиа  
Инээд биш ханиад  
Наадам биш навхраас  
Инээд биш ханиад  
Элэг биш уушиг  
“Инээмээр биш зүйлд инээлдээд байх хэрэггүй байжээ гэсэн гэмшил боловч наргиа маягийн үг юм. Инээд эзнээ олохгүй бол ханиад, ичгүүр болдог гэсэн санаа” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.202 б).

Энэхүү гурван зүйл зүйр цэцэн үг нь агуулгынхаа талаас ойролцоо утгат хэллэгийн шинжийг агуулсан нь тодорхой бөгөөд “инээд биш ханиад” гэсэн эхний мөр нь гурвууланд нь ижил бол эхний хоёр зүйр цэцэн үгийн гурав дахь мөрүүд нь “наадам биш наргиа”, “наадам биш навхраас” гэдгээрээ ойролцоо зэргэд үүсгэж, харин сүүлийн зүйр цэцэн үгийн сүүлийн мөр нь “элэг биш уушиг” гэж өвөрмөцөөр холбогджээ.

Чамд инээд  
Над ханиад  
“Чамд баяр над зовлон, хүний зовлонг ойлгохгүй байна гэсэн хэллэг” (Болд, 2008, х.1116 б), “Миний зовлонгоор доог дохуу хийлээ гэсэн гоморхол болно. Үүнийг “Энд инээд, тэнд ханиад” гэх. Энэ нь бусдын зовлонгоор тохуурхах гэсэн зэвүүцэл” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.588 а).

Чамд инээдэм  
Над ханиадам  
“Нэгд нь инээдтэй юм нөгөөд нь зовлонтой санагдах” (Аким, 2011, х.155).

Энэ хоёр зүйр цэцэн үг нь төсөөт хэллэгийн эгнээ үүсгэсэн нь тодорхой харагдаж байна.

Инээд болоход хөгтэй  
Ханиад болоход гэмтэй  
“Инээд бол сэтгэлийн хөөрөл, хөгжил, баяслыг илэрхийлдэг бол ханиад өвчин болно. Иймд энэ хоёр эсрэг үзэгдлийг хоршин хэрэглэх нь хэтэрхий их инээд муу гэсэн санаа юм. Жишээ нь: «Инээд ээтэй ханиад ханьтай» гэх хэллэг байх” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.202 б-203 а).

Инээд ээтэй  
Ханиад халтай  
Инээд ханиадны эгч  
Элэг дэлүүний нагац

“Хэрэгцээ багатай тааруухан юмнууд (хүмүүс) ижилсэж бие биеэ дэмжиж газар авдаг гэсэн егөөдөл үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 а).

Өглөөний инээд  
Үдшийн ханиад

“Яагаа яагаа ч үгүй эрт баярлаж хөөрч хөөрцөгдөж болохгүйг үлгэрлэсэн хэллэг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.311 а).

#### (г) инээх – идэх

Энэ хэв шинжийн зүйр цэцэн үгийн түүвэр болон холбогдох тайлбар, ажиглалт дүгнэлтийг дараах байдлаар товчоолон үзүүлье. Үүнд:

Идсэн өдөр цагталан  
Инээсэн өдөр баясгалан  
Идсэн өдөр цагталан  
Инээсэн өдөр жаргалан

“Ерөнхийдөө ядуу зүдүү олны хишиг харж горилж явдаг өрөвдөлтэй зан байдлыг үлгэрлэсэн үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.196 б) билээ.

Эл хоёр зүйр цэцэн үг нь “баясгалан - жаргалан” хэмээх ойролцоо утгат үгийн эгнээнд үндэслэсэн хувилбар буюу төсөөт хэллэгүүд болох ажээ.

Инээх дүр нь нүүрэн дээр  
Идэх санаа нь элгэн дотор  
Инээх дүр нь царайндаан  
Идэх санаа нь чээжиндээн  
Инээсэн дүр нь найрандаа  
Идэх санаа нь цээжиндээ  
“Наанаа найрсаг сайхан аашлавч, цаанаа ямар ч муу юм хийж мэдэх итгэмжгүй этгээд гэсэн санаа” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 а).

Эдгээр гурван зүйр цэцэн үг нь бас л хувилбар харьцаатай бөгөөд эхний мөрүүдийн “инээх дүр” нь “... нүүрэн дээр”, “... царайндаан”, “... найрандаа” хэмээн үгийн сангийн болон хам сэдвийн ойролцоо үгээр холбогдсон бол хоёр дахь мөрүүдийн “идэх санаа” нь “... элгэн дотор”, “... чээжиндээн”, “... цээжиндээ” гэсэн ойролцоо болон төсөөт үгээр холбогдсон байна.

Их инээсэн хүн хүндээ барах  
Их идсэн хүн ходоодоо барах

#### (д) инээх - ирэх

Энэ хэв шинжийн зүйр цэцэн үгийн түүвэр болон холбогдох тайлбар сэлтийг дараах байдлаар товчоолон үзүүлье. Үүнд:  
Инээсэн бүхэн гэмтэй

Ирсэн хүн учиртай  
Инээсэн хүн өетэй  
Ирсэн хүн учиртай  
“Хүмүүсийн харилцааны шинж төрхийг илэрхийлэх хэллэг. Үүний эерэг сайн, сөрөг муу хоёр талтай үзэж болно” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 а).

Ирмэсэнд итгэдэггүй  
Ирсэнд инээдэггүй  
“Хүний аяг аашинд зохицуулан харилцахыг анхааруулсан сургамж үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 б).

#### (е) инээх - сургах

Энэ хэв шинжийн зүйр цэцэн үгийн түүвэр болон холбогдох тайлбар сэлтийг дараах байдлаар товчоолон үзүүлье. Үүнд:  
Инээх хүн олон олодох  
Сургах хүн цөөн олодох  
“Аливаа явдал учралд сайнаасаа саар нь илүү тохиолдохыг санамж болгон хэлдэг үг” бөгөөд (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 б) энэхүү зүйр үгэнд “инээх” гэдэг үгийг “сургах” гэдэг үгтэй эсрэгцүүлэн эсрэг үгийн эсрэгцлийн эгнээ үүсгэсэн нь сонирхолтой юм.

#### (ё) инээх - унтах

Энэ хэв шинжийн зүйр цэцэн үгийн түүвэр болон холбогдох тайлбар сэлтийг дараах байдлаар товчоолон үзүүлье. Үүнд:  
Аальгүй хүүхэн инээмтгий  
Ажилгүй хүн унтамтгай  
“Буруу зан төрх, буруу хүмүүжлийн үр дагавар нь худал инээж, залхуурч унтах гэсэн зэвүүцэл, зэмлэл” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.9 б) хэмээжээ.

Тэрчлэн “инээх” үгт зүйр цэцэн үгийн хүрээнд холбогдох янз бүрийн бүтэц, хэлбэржилт бүхий зүйр цэцэн үг бүртгэгдсэнийг өгүүллийн эцэст жагсаан оруулж байна. Үүнд:

Дээд биеийнхэн инээлдэхэд  
Доод биеийнхэн марзалзана  
Дээд бие дэх инээлдэхэд  
Үүдэн бие дэх марзганадаг  
“Хүмүүс эрэмбэ зиндаа ямагт ялгаатай тул дээгүүрх хүмүүсийн аяг аашийг доогуурх нь хуурмаг зусарддаг эсвэл шоолдог гэсэн егөөдөл” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.149 б) үг байна.

Энэхүү хоёр зүйр цэцэн үг нь ойролцоо утгат хэллэгийн эгнээ үүсгэсэн байна.

Тал өгч худал инээснээс  
Танихгүй хүн шиг дуугүй яв

“Тус хүргэж чадахгүй бол хөндийхөн, зай барьж яв гэсэн санамж” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.380 а).

Ховч хүний хошуу хүйтэн  
Худалч хүний яриа хүйтэн  
Хулгайч хүний нүд хүйтэн  
Хуурамч хүний инээд хүйтэн  
Хулгайч нохой хуцахаараа  
Хуйхар хүүхэн инээхээрээ

“Хүн ба адгуусны муу араншинг харьцуулсан шог үг. “Хулгайч нохой хуцаж ирдэг, худал ч хүн инээж ирдэг” гэх ч буй” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.531 б).

Шалтаггүйгээр инээд гарахгүй  
Шаваргүйгээр байшин босохгүй

“Инээд хэмээх сэтгэцийн үзэгдэл ямар нэг учир шалтагаанаар үүсдэгийг бодит үйлтэй зүйрлэсэн хэллэг”(Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.596 а) байна.

Булгийн ус оргивч хүйтэн  
Буруу санаат инээвч худал

“Наана инээж сайхан аяг ааш гаргавч худал хуурмаг зантай этгээдийг булгийн усны хүйтэнтэй зүйрлэж хэлсэн үг” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.87 б) утгын илэрхийлсэн нь харагдана.

Инээдгийг эр дагадаг

Бааранг нохой дагадаг

“Авгай хүүхнүүд олноор цугларсан газар инээдэм шуугиан их байдаг. Тийшээ эрчүүд явах нь өөрийн сонирхсон зүйлдээ явж байгааг зүйрлэсэн нь хэрэгцээ хаана байна, тийшээ гэсэн хошигнол” (Ням-Осор, Өлзийсүрэн, 2011, х.203 а) утгын илэрхийлэл болжээ.

Хэдэр ярдаггүй төвшин төлөв яв

Хэлэх бүхэнд инээмсэглэн зохистой аашил

Түүнчлэн орчин цагийн монгол хэлэнд “инээх” үгт зүйр цэцэн үгээс гадна “инээх” үг оролцсон инээд алдах “тэсгэлгүй инээх” (Болд, 2008, х.1116 а), *хөх инээд хүрэх* “хүнийг басамжлах, энгүүтэй инээх” (Аким, 1999, х.167), “а. Дургүйлхэн хорссон байдал гаргах, зэвүүцэх; б. Басамжлах, тавлах” (Болд, 2008, х.1116 б), *хөх инээд хүргэх* “тавлах, басамжлах” (Сүлд-Эрдэнэ ба бус., 2013), элгээ хөштөл инээх “ихэд инээх” (Аким, 1999, х.195), инээд ханиад болох “хөөрөн найрч наргиан дэвжээн болох”(Сүлд-Эрдэнэ ба бус., 2013), хүйтэн инээд “хорсч басамжилсан инээд” (Болд, 2008, х.1116 б) гэх мэтийн хэлц үг арвин байгаа бөгөөд энэ бүхэн нь дараа дараагийн судалгааны хэрэглэгдэхүүн болох байх хэмээн үзэж байна.

## Дүгнэлт

Монгол ардын аман зохиолын нэгэн томоохон төрөл зүйл болох зүйр цэцэн үгийн сан хөмрөг дотроос “инээх” үгт зүйр цэцэн үгийг тусгайлан сонгож үүнд холбогдох баримт хэрэглэгдэхүүнийг боломжийн хэрээр бүртгэн

цуглуулж, өөрийн чадахын хэрээр ажиглалт туршилт хийснийхээ үндсэн дээр дараах зүйлийг эмхлэн хэлж болох юм гэж үзлээ. Үүнд:

- Монгол хэлний “инээх” үгт зүйр цэцэн үг нь бүтэц, хэлбэржилтийн хувьд хоёрлосон буюу хоёртын зэргэд дээр үүссэн байна. Дөрвөлсөн зэргэд цөөн бүртгэгдсэн бөгөөд энэ нь угтаа хоёрлосон зэргэдийг мөрийн хувьд өргөтгөсөн зүйл юм гэж үзлээ.

- “Инээх” үгт зүйр цэцэн үгийн хоёрлосон бүтэц нь эсрэг үгийн харьцаан дээр тулгуурлаж улмаар эсрэгцсэн эгнээ буюу эсрэгцсэн хоёр мөртгийг үүсгэдэг онцлогтой байна. Энэ бол ерөөсөө монгол хэлний зүйр цэцэн үгийн өвөрмөц онцлогуудын нэг юм гэж хэлж болно.

- Бидний тухайлан сонгож авсан зүйр цэцэн үгийн бүрэлдүүнд орсон “инээх” гэдэг үгийн утгазүйн орон үүсгэх чадамж нь “уйлах”, “уурлах”, “ханиах”, “идэх”, “ирэх”, “сургах”, “унтах” зэрэг үгтэй холбогдсон байна. Эдгээр үгийн эхний хоёр нь үгийн сангийн эсрэг үг, бусад нь хам сэдвийн эсрэг үгийн харьцаа үүсгэсэн шинжтэй байна.

- “Инээх” үгт зүйр цэцэн үгийн гол үг болох “инээх” нь дээрх үйл үгтэй эсрэгцэн холбогдож утгазүйн орон үүсгэснээрээ нэн онцлог юм.

## Ашигласан материал

Аким, Г. (1999). Монгол хэлний өвөрмөц хэллэгийн товч тайлбар толь. Улаанбаатар.

Аким, Г. (2011). Монгол зүйр цэцэн үгийн товч тайлбар толь. Улаанбаатар.

Бадамдорж, Д. (2006). Монгол хэлний үгийн сангийн утгазүй. Улаанбаатар.

Болд, Л. (ред.), (2008). Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. 5 боть. “Бемби сан” хэвлэх үйлдвэр. Улаанбаатар.

Гаадамба, Ш., Сампилдэндэв, Х. (1978). Монгол ардын аман зохиол. Улаанбаатар.

Гаадамба, Ш., Цэрэнсодном, Д. (1978). Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Хоёр дахь хэвлэл. Улаанбаатар.

Далайжамц, Ё.(эмх.), “он т-бус”, Ардын аман зохиолын цуврал-1. Улаанбаатар. Кузьменков, Е.А., (1984). Глагол в монгольском языке.

Ням-Осор, Н., Өлзийсүрэн, Б., (2011). Монгол хэлний зүйр, цэцэн үгийн товч тайлбар толь. Түмэн толгой үг. Улаанбаатар..

Ринчэнсамбуу, Г., Дашдорж, Ж. (2009). Монгол ардын зүйр цэцэн үг. Улаанбаатар.

Ринчэнсамбуу, Г., (эмх.), (2009). Монгол зүйр цэцэн үг. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар.

Сүлд-Эрдэнэ, Г., Уянга, Б., Нямаа, Д., Баасанбат, Д., Баярсайхан, Б. (2013). Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь. Улаанбаатар: Монсудар

Цэрэнсодном, Д. (2012). Монгол аман зохиолын тайлбар дээж бичиг. Улаанбаатар.

Эрдэнэ - Очир, Г. (1983). Зарим зүйр цэцэн үгийн утгын товч тайлбар. Улаанбаатар: АБЯ-ны хэвлэл